



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/ИЗ

Мандалговь

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22 ны өдрийн 266 дугаар тогтоол, хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэх журмыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ: нь

1.Тус сумын Тэвш багийн нутаг "Бага булаг" /N46.06.05.2/ /E105.58.55.5/ гэх газарт шүлхий өвчний голомт үүссэн тул 2021 оны 08 сарын 21-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэмийг тогтоосугай.

2.Гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д даалгасугай.

3.Хорио цээрийн бүсэд хийгдэх халдваргүйтгэл, дархлаажуулалтын товыг зарлаж мал сүргийг бүрэн хамруулж ажиллахыг мал эмнэлгийг үйлчилгээний нэгжийн эмч, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Е.Отгонцэцэг)-т, тархвар зүйч эмч (Д.Эрдэнэцэцэг)-т нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

